



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@moj.gov.mn,
<http://www.moj.gov.mn>

2015. 07. 10 № 3 / 2824
танай 2015. 07. 02 ны № 7 / 2797 Т

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г. ГАНЧИМЭГ ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Журам батлах тухай” 254 дүгээр тушаалыг хүлээн авч, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн сангийн 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 3439 дугаарт бүртгэлтэй Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын баталсан 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам батлах тухай” А/21 дүгээр тушаалд холбогдох хөдөлгөөн хийснийг мэдэгдье.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЗОРИГТ



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. "Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах журам"-ыг хоёрдугаар, "Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах журам"-ыг гуравдугаар, "Сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх болон ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангах, үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулах спортын холбоодын орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны А/21 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Бүртгэлийн дугаар

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН
ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

D:\barimt\tushaal

2015 оны 06 сарын 30

080862



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. “Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах журам”-ыг хоёрдугаар, “Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах журам”-ыг гуравдугаар, “Сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх болон ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангах, үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулах спортын холбоодын орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-т үүрэг бопгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны А/21 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal
080861

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 30 өдрийн
254 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

“НАСАНД ХҮРЭГЧДИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрөл, ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах ажлыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан орон тооны бус Зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн тухайн спортын холбооны сонгон шалгаруулах зөвлөл /цаашид Холбооны зөвлөл гэх/ нь үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчныг сонгон шалгаруулах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

1.4. Улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд:

1.4.1. Олон Улсын Олимпын Хорооны ивээл дор явагдаж байгаа олон улсын шинжтэй тэмцээн, наадамд Монгол Улсыг төлөөлж оролцох тамирчдыг бэлтгэх зорилгоор өмнөх Олимп, Паралимпын наадамд албан ёсны эрх авч оролцсон төрлүүдээр наадам дууссан өдрөөс хойш 90 хоногийн дотор насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг дараагийн олимп, паралимпын наадмыг дуустал бүрдүүлнэ.

1.4.2. Олон улсын шинжтэй тэмцээн, наадамд Монгол Улсыг төлөөлж оролцох тамирчдыг бэлтгэх зорилгоор тодорхой болзол, хугацаатайгаар тухайн жилийн төсөв, санхүүгийн байдалтай уялдуулан гэрээний дагуу зуны спортын төрлүүдээр жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор, өвлийн спортын төрлүүдээр жил бүрийн 06 дугаар сарын 30-ны дотор насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлнэ.

1.5. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг яамны харъяа Биеийн тамир, спортын хөгжлийн төв хариуцна.

1.6. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчныг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг тухайн спортын холбоо хариуцна.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрх

2.1. Зөвлөлийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан Дэд сайд тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд яамны Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, үндэсний шигшээ багийн асуудал хариуцсан мэргэжилтэн, спортын холбоодын асуудал болон хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЭМСЯ-ны харъяа Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Монголын Үндэсний Олимпын Хороо,


Монголын Паралимпийн Хорооны төлөөлөл орно.

- 2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 2.3. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 2.3.1. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах,
 - 2.3.2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах,
 - 2.3.3. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах мэргэжлийн комиссийн бүрэлдэхүүнийг сайдаар батлуулах,
 - 2.3.1. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтын явцад хяналт тавих;
 - 2.3.4 Спортын холбооны зөвлөлийн шалгаруулсан дасгалжуулагч, тамирчдын сонгон шалгаруулалтад хяналт тавих, тэнцсэн дасгалжуулагч, тамирчдын нэрсийг сайдад танилцуулах, шийдвэрийг гаргуулах
 - 2.3.5 Сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд мэдээлэх;
- 2.4. Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Үнлэсний шигшээ багийн алба хариуцна.
- 2.5. Зөвлөл нь хурлаар хэлэлцсэн асуудлаа хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.6. Зөвлөл сонгон шалгаруулалттай холбоотой Биеийн тамир, спортын хөгжлийн төв, спортын холбоо, дасгалжуулагчдын гаргасан санал, хүсэлт, тамирчны хувийн өргөдлийг хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж Сайдад танилцуулна.
- 2.7. Тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурсан байна.
- 2.8. Үндэсний шигшээ багийн тамирчин сонгон шалгаруулах журмын 4, 5 дугаар зүйл, насанд хүрэгчдийн шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулах журмын 4, 5 дугаар зүйлийг баримтлан Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Сайд баталгаажуулан Биеийн тамир, спортын хөгжлийн төвд хүргүүлнэ.

Гурав. Спортын төрлийг сонгох шалгуур үзүүлэлт

- 3.1. Улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн спортын төрлийг зохих болзол шалгуурыг хангасан байдлыг үнэлж спортын тодорхой төрөл, зай, жингээр бүрдүүлнэ.
- 3.2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэхэд өмнөх Олимпийн наадамд эрх авч оролцоогүй спортын төрлийг /цаашид спортын төрөл гэх/ сонгохдоо шударга өрсөлдөөн, ил тод байдлын зарчмыг үндэслэн тухайн спортын төрлөөр тамирчдын амжилтын тогтвортой байдал, залгамж шинж чанар, өндөр амжилт гаргах магадлал зэргийг тооцон үзнэ.
- 3.3. Спортын төрлийг сонгохдоо дараах шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:
 - 3.3.1. тухайн спортын төрлөөр дэлхийн аварга шапгаруулах тэмцээнд сүүлийн гурван жил медальт болон шагналт байранд шалгарсан байдал,
 - 3.3.3 тухайн спортын төрлөөр Ази тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт болон шагналт байранд шалгарсан байдал,
 - 3.3.4 тухайн спортын төрлөөр бэлтгэгдсэн мэргэжлийн дасгалжуулагчийн хүрэлцээ, мэргэшсэн байдал,

- 3.3.5 материаллаг баазын хүрэлцээ хангамж,
1. спортын холбооноос үндэсний шигшээ багт зарцуулсан зардлын хэмжээ. /сүүлийн 3 жилээр/



Дөрөв. Нэр дэвших спортын төрлийг сонгон шалгаруулах

4.1. Зөвлөл улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн сонгон шалгаруулалтыг энэ журмын 1.4.1, 1.4.2-т заасан хугацаанд явуулах бөгөөд шалгаруулалт эхлэхээс хуанлийн 20-оос доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

4.2. Зарлалд сонгон шалгаруулалтад спортын төрлөө нэр дэвшүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, бүртгүүлэх хугацаа, бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

4.3. Сонгон шалгаруулалтад оролцох спортын холбоод дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлнэ.

4.3.1. Нэр дэвшүүлэх тухай холбооны хүсэлт, /шигшээ баг бүрдүүлэх үндэслэл, хүрэх үр дүнг тодорхой дурьдсан байна/

4.3.2. Олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны батламж

4.3.3. "Төрийн бус байгууллагын тухай хууль"-ийн 23 дугаар зүйлд заасан тайлангын хувь

4.3.4. журмын 3.3-т заасан бүртгэл мэдээлэл, судалгааны материалууд,

4.3.5. үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, төсөв

4.4. Спортын холбоодын нэр дэвшүүлэх хүсэлтийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өдрөөс 5 хоногийн өмнө дуусгавар болгоно.

4.5. Зөвлөл нь сонгон шалгаруулалт зохион байгуулсан өдрөөс хойш 5 хоногт багтаан дүгнэлтийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

4.6. Журмын 1.4.2. дахь заалтын дагуу сонгогдсон тухайн төрлийн спортын холбоотой Үндэсний шигшээ багийн асуудал хариуцсан төрийн байгууллагаас байгуулсан гэрээний хэрэгжилтийг үндэслэн улсын төсвийн дэмжлэгийг үргэлжлүүлэн өгөх эсэхэд Зөвлөл дүгнэлт гарган Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

Тав. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ангилал, санхүүжилт

5.1. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг бүрдүүлж буй спортын төрөл болон төрөл тус бүрийн тамирчин, дасгалжуулагчдыг улсын төсвөөс үзүүлж буй дэмжлэгээр нь байнгын болон байнгын бус гэж ангилна.

5.2. Үндэсний шигшээ багийн байнгын гишүүнд "Биеийн тамир, спортын тухай хууль"-д зааснаар улсын төсвөөс дэмжлэг үзүүлэн ажиллана.

5.3. Үндэсний шигшээ багийн байнгын бус гишүүнд цалингаас бусад дэмжлэгийг улсын төсвөөс үзүүлнэ.

5.4. Үндэсний шигшээ багийн гишүүд байнгын болон байнгын бус ангиллаас үл хамаарч Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн удирдлагатай контракт болон Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу тамирчин, дасгалжуулагчийн үйл ажиллагааны гэрээ байгуулан ажиллана.

5.5. Тамирчин, дасгалжуулагчийн үйл ажиллагааны гэрээ нь контрактин салшгүй хэсэг байна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 30 өдрийн
15.4 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

НАСАНД ХҮРЭГЧДИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН АХЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон Улсын Олимпийн Хорооны ивээл дор явагдаж байгаа болон олон улсын шинжтэй тэмцээнд Монгол Улсыг төлөөлж оролцох насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчийг сонгон шалгаруулахад энэхүү журмыг баримтлана.

1.2. Улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчын сонгон шалгаруулалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан журмын 1.2-т заасан Зөвлөл, дасгалжуулагчын сонгон шалгаруулалтыг 1.3-т заасан Холбооны зөвлөл зохион байгуулна.

1.3. Улсын төсвийн дэмжлэг авах насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчийг сонгон шалгаруулахдаа шударга өрсөлдөөн, ил тод байдлын зарчмыг үндэслэн бэлтгэсэн тамирчдын амжилт, мэргэжил, мэргэшлийн мэдлэг, ур чадвар, туршлага, манлайлал, сахилга бат, ёс суртахуун зэргийг тооцон үзнэ.

1.4. Ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчид үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөө, үзэл бодлыг хүндэтгэн, удирдах, удирдуулах ёсыг эрхэмлэн ялгаварлан гадуурхах, дарамтлах, бэлгийн дарамт, шударга бус өрсөлдөөн, ашиг сонирхлын зөрчил, авлига хээл хахуулиас ангид байх зарчмыг баримтлана.

1.5. Олимпийн наадмаас алтан медальтан төрүүлсэн дасгалжуулагч насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, спортын холбоотой зөвшилцсөний үндсэн дээр тухайн спортын төрөлдөө үндэсний шигшээ багийн орон тооны бус зөвлөх дасгалжуулагчаар хамтран ажиллаж болно.

1.6. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчыг сонгон шалгаруулж, баталгаажсаны дараа Холбооны зөвлөлөөр үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдыг сонгон шалгаруулна.

Хоёр. Холбооны зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх

2.1. Холбооны Зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Дасгалжуулагчийн зөвлөлийн төлөөлөл, Шүүгчийн зөвлөлийн төлөөлөл, ЭМСЯ-ны харъяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн төлөөлөл орно.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.3. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн дасгалжуулагчыг сонгон шалгаруулах,

2.3.2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн дасгалжуулагчыг сонгон шалгаруулах мэргэжлийн комиссийн бүрэлдэхүүнийг Холбооны ерөнхийлөгчөөр батлуулах,

2.3.3. сонгон шалгаруулсан дасгалжуулагчийн нэрсийг холбогдох материалын хамтаар Зөвлөлд хүргүүлэх,

2.4. Холбооны зөвлөл нь хурлаар хэлэлцсэн асуудлаа хуралд оролцож буй гишүүдийн олонхийн санаагаар шийдвэрлэх бөгөөд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.5. Холбооны зөвлөл үндэсний шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдыг сонгон шалгаруулж Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчтай зөвшилцөнө.

2.6. Тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурсан байна.

Гурав. Ахлах дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтыг зарлах, мэдээлэх

3.1. Сонгон шалгаруулалтын товыг шалгаруулалт эхлэхээс 20 хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах бөгөөд дараах зүйлийг тусгана;

3.1.1. сонгон шалгаруулалт явуулах газар, огноо, цаг,

3.1.2. сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх хугацаа,

3.1.3. сонгон шалгаруулалтад бүрдүүлэх материал.

3.2. Сонгон шалгаруулалтын тухай мэдээ, мэдээллийг Эрүүл мэнд, спортын яам /mohs.gov.mn/, Биеийн тамир, спортын хөгжлийн төв /sport.gov.mn/, Спортын холбооны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх:

4.1. Нэр дэвшигч нь спортын клуб, харьяалах байгууллагын тодорхойлолтоор болон бие даан сонгон шалгаруулалтад орж болно.

4.2. Сонгон шалгаруулалтанд оролцох нэр дэвшигчид сонгон шалгаруулалт эхлэхээс 5 хоногийн өмнө спортын холбоондоо бүртгүүлсэн байна.

4.3. Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ Үүнд;

4.3.1. Өргөдөл

4.3.2. Төрийн албан хаагчийн анкет, маягт 1

4.3.3. Иргэний үнэмлэхний хуулбар, /нотариатаар баталгаажуулсан/

4.3.4. Мэргэжлийн диплом болон мэргэжил дээшлүүлсэн үнэмлэх, диплом, сертификатын хуулбар, /нотариатаар баталгаажуулсан/

4.3.5. Нийгмийн даатгал болон хөдөлмөрийн дэвтрийн хуулбар,

4.3.6. Хүн амын орлогын албан татварын дэвтрийн хуулбар,

4.3.7. Спортын цолны үнэмлэхний хуулбар,

4.3.8. Цээж зураг 4 хувь, /3x4/.

4.3.9. Эрүүл мэндийн ерөнхий үзлэгт орсон магадлагаа,

4.3.10. Ажлын дадлага туршлагын тухай урьд ажиллаж байсан байгууллага, үндсэн байгууллагын болон тухайн спортын хороо, холбооны тодорхойлолт,

Тав. Сонгон шалгаруулалт:

5.1. Тухайн спортын төрлийн насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгон шалгаруулахдаа Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан шалгалтын комисс мэргэжлийн болон хэлний шалгалтыг авч, ажлын хэсэг материалын бүрдүүлэлтийг хүлээн авч Зөвлөл ярилцлагыг авна.

- 5.1.1. материалын бүрдүүлэлт /10 оноо/
- 5.1.2. мэргэжлийн шалгалтын дүн /60 оноо/
- 5.1.3. хэлний шалгалт /10 оноо/
- 5.1.4. ярилцлага /20 оноо/

5.2. Нэр дэвшигч нь ярилцлаганд орохдоо үндэсний шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, амжилтыг тогтмол түвшинд хадгалах үүднээс ажиллах баг дээр хэрэгжүүлэх жил болон 4 жилийн хөтөлбөр, төлөвлөлт, төлөвлөгөөний төсөл, гадаад, дотоодын өрсөлдөгчийн судалгааг хийсэн байна.

5.3. Зөвлөлийн гишүүд ярилцлага авна.

5.4. Мэргэжлийн шалгалтанд 40-өөс дээш оноо авсан тохиолдолд хэлний шалгалт болон ярилцлагад орох эрх үүснэ. Мэргэжлийн шалгалтад тэнцсэн нь сонгон шалгаруулалтад бүрэн тэнцэх үндэслэл болохгүй.

5.5. Ажлын хэсэг нь насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчийг сонгон шалгаруулахдаа мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдал, ажлын туршлага, манлайлал, сахилга бат, ёс зүй, харилцааны соёл, бэлтгэсэн тамирчдын амжилт зэргийг харгалзан бичиг баримтын бүрдэл, мэргэжлийн шалгалтын дүн, хэлний шалгалт, ярилцлагын онооны нийлбэрээр нь спортын төрөл тус бүрээр эрэмблэн байр эзлүүлнэ.

5.6. Үндэсний шигшээ багийн дасгалжуулагчын сонгон шалгаруулалтад нэр дэвшигчдээс тэнцээгүй тохиолдолд дараагийн сонгон шалгаруулалтыг явуулна.

5.7. Нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд;

- 5.7.1. Биеийн тамир, спортын их, дээд сургууль төгссөн байх.
- 5.7.2. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх,
- 5.7.3. Өндөр зэрэглэлийн тамирчидтай ажиллаж байсан туршлагатай байх.
- 5.7.4. Удирдсан тамирчид тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн байх. /протоколоор баталгаажна/
- 5.7.5. Харилцааны өндөр соёлтой, хүний эрхийн талаар мэдлэгтэй байх,
- 5.7.6. Багаар ажиллах чадвартай, сүүлийн 1 жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчилгүй, ёс зүй, сахилгын шийтгэлгүй байх.
- 5.7.7. Интернетийн орчинд ажиллах. гадаад хэлний /орос, англи/ зохих түвшний мэдлэг, ярианы чадвартай байх. /шалгалт/
- 5.7.8. Сургалт - дасгалжуулалтын онол, арга зүй, технологи болон спортын анагаах ухааны мэдлэгтэй байх, /шалгалт ба ярилцлага/
- 5.7.9. Спортын анагаах ухаан, тамирчны бэртэл гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламж, допингийн эсрэг зохих түвшний мэдлэгтэй байх /шалгалт ба ярилцлага/

5.8. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн дасгалжуулагчийг энэ журмын 5.1–5.4 дэх заалтыг баримтлан Холбооны Зөвлөл сонгон шалгаруулна.

5.9. Холбооны зөвлөл сонгон шалгаруулалт дууссанаас 3 хоногын дотор тэнцсэн нэр дэвшигчдийн нэрсийг холбогдох материалын хамтаар Зөвлөлд ирүүлнэ.

5.10. Зөвлөл сонгон шалгаруулалтын дүн, материалыг хянаж, дасгалжуулагчийг томилуулах дүгнэлтийг гарган Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

5.11. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөлийн

дүгнэлтийг баталгаажуулан ажлын 10 хоногт багтаан Эрүүл мэнд, спортын яамны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвд хүргүүлнэ.

Зургаа. Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчийг чөлөөлөх:

6.1. Дараахь тохиолдолд ахлах дасгалжуулагч, дасгалжуулагчийг Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх үндэслэл болно.

- 6.1.1. дасгалжуулсан баг, тамирчдын амжилт буурсан, гэрээнд тусгасан амжилтын зорилтоо биелүүлээгүй буюу биелүүлэхээс татгалзсан үйл ажиллагаа явуулсан,
 - 6.1.2. эрүүл мэндийн хувьд ажиллах боломжгүй болсон нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон, хариуцсан багийн тамирчдыг ялгаварлан гадуурхсан, хүчирхийлэл хэрэглэсэн нь хуулийн байгууллагаар тогтоогдсон,
 - 6.1.3. гадаад улс оронд тэмцээн, наадамд оролцох үедээ улс орны нэр хүндийг унагаасан аливаа үйлдэл гаргаж олон улсын спортын холбооноос арга хэмжээ авсан, тэмцээнд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хассан,
 - 6.1.4. дасгалжуулагч өөрийн буруутай үйлдлээр баг, тамирчдаа тэмцээн, наадам, тойргын тоглолт, барилдаан, тулаан, гараанаас хоцроосон,
 - 6.1.5. гадаад, дотоодын бэлтгэл цугларалтад гарсан үед хүндэтгэх шалтгаангүйгээр тамирчид болон байраа орхин явсан,
 - 6.1.6. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хүний эрхийн зөрчил гаргасан, тамирчиддаа допинг хэрэглэхийг зөвшөөрсөн, шахсан, хэрэглэхийг завдсан зэрэг нь нотлогдсон тохиолдолд,
 - 6.1.7. ажлын байранд, гадаад, дотоодод бэлтгэл цугларалтад гарах, тэмцээн наадамд оролцох үедээ архидан согтуурсан, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн,
- 6.2. Энэ журмын 6.1 дэх зүйлд заасан шийдвэрийг гарсан даруйд Эрүүл мэнд, спортын яам, Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Спортын холбооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06. сарын 30. өдрийн
254 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

НАСАНД ХҮРЭГЧДИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН ТАМИРЧИН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон улсын олимпийн хорооны ивээл дор явагдаж байгаа болон олон улсын шинжтэй тэмцээнд Монгол Улсыг төлөөлж оролцох тамирчдыг бэлтгэх зорилгоор насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийн тамирчинг сонгон шалгаруулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн тамирчны сонгон шалгаруулалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан журмын 1.3-т заасан Холбооны зөвлөл зохион байгуулна

1.3. Сонгон шалгаруулалтыг шударга өрсөлдөөн, ил тод байдлын зарчмыг үндэслэн Олимп, тивийн наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээн, улсын аварга шалгаруулах тэмцээний амжилт, өндөр амжилт гаргах магадлал, сахилга бат, ёс суртахуун, спортын ур чадвар зэргийг тооцон тухайн спортын холбооноос баталсан болзлын дагуу насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулна.

1.4. Олимп, паралимпийн наадамд албан ёсны эрх авч оролцсон спортын төрлүүдийн Үндэсний шигшээ багийн тамирчдыг сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс шинэчилсэн бүрэлдэхүүнийг Олимп, паралимпийн цикл дууссан өдрөөс хойш 90 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Хоёр. Холбооны зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрх

2.1. Холбооны Зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Дасгалжуулагчийн зөвлөлийн төлөөлөл, Шүүгчийн зөвлөлийн төлөөлөл, ЭМСЯ-ны харъяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн төлөөлөл орно.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.3. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.3.1. насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн тамирчныг сонгон шалгаруулах,

2.3.2. сонгон шалгаруулсан тамирчдын нэрсийг холбогдох материалын хамтаар орон тооны бус Зөвлөлд хүргүүлэх,

2.4. Холбооны зөвлөл нь хурлаар хэлэлцсэн асуудлаа хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.5. Тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурсан байна.

Гурав. Сонгон шалгаруулалтыг зарлах, мэдээлэх

3.1. Сонгон шалгаруулалтын товыг шалгаруулалт эхлэхээс 20 хоногийн өмнө олон

нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах бөгөөд дараах зүйлийг тусгана;

- 3.1.1. сонгон шалгаруулалт явуулах газар, огноо, цаг,
- 3.1.2. сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх хугацаа,
- 3.1.3. сонгон шалгаруулалтад бүрдүүлэх материал,
- 3.1.4. Сонгон шалгаруулалтын тухай мэдээ. мэдээллийг Эрүүл мэнд, спортын яам /mohs.gov.mn/, Биеийн тамир, спортын хөгжлийн төв /sport.gov.mn/, Спортын холбооны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх

- 4.1. Нэр дэвшигч нь спортын клуб, харьяалах байгууллагын тодорхойлолтоор болон бие даан сонгон шалгаруулалтад орж болно.
- 4.2. Сонгон шалгаруулалтанд оролцогчид сонгон шалгаруулалт эхлэхээс 5 хоногийн өмнө спортын холбоондоо бүртгүүлсэн байна.
- 4.3. Бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд;
 - 4.3.1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл,
 - 4.3.2. Төрийн албан хаагчийн анкет,
 - 4.3.3. Дэлгэрэнгүй танилцуулга, /Спортоор хичээллэж эхэлсэн огноо, жил, хичээллэж байгаа клуб, анхны болон одоо дасгалжуулж буй дасгалжуулагчийн нэр/
 - 4.3.4. Спортын амжилтын танилцуулга, /тэмцээний протоколоор баталгаажна/
 - 4.3.5. Спортын цолны үнэмлэх,
 - 4.3.6. Үндсэн байгууллагын болон спортын хороо, холбооны тодорхойлолт,
 - 4.3.7. Цээж зураг 3x4 хэмжээний 4 хувь,
 - 4.3.8. Эрүүл мэндийн үзлэгт орсон магадлагаа, /Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, нүд, чих, хамар хоолой, мэс засал, эмэгтэйчүүд, гэмтэл, дотор, зүрх судас, сэтгэц, арьс өнгө/
 - 4.3.9. Эрүүл мэндийн шинжилгээ, /биохими-элэгний үйл ажиллагаа, нойр булчирхайн үйл ажиллагаа, цус, шээсний ерөнхий шинжилгээ, элэг, дэлүү, бөөр, өндгөвч, умай, хеликобактер/

Тав. Сонгон шалгаруулалт

- 5.1. Хувь тамирчны үзүүлсэн амжилт, ерөнхий ажиллах чадварын үзүүлэлт, тухайн спортын төрлийн онцлогт тохирсон үзлэг, сорил, тест, спортын анагаах ухааны албаны дүгнэлтийг тус тус үндэслэн тухайн Холбооны зөвлөл тамирчдыг спортын төрлийн зай, жин тус бүрээр эрэмблэн шалгаруулна.
- 5.2. Холбооны зөвлөл сонгон шалгаруулалт дууссанаас 3 хоногийн дотор тэнцсэн нэр дэвшигчдийн нэрсийг холбогдох материалын хамтаар Зөвлөлд ирүүлнэ.
- 5.3. Зөвлөл сонгон шалгаруулалтын дүн, материалыг хянаж, тамирчныг томилуулах дүгнэлтийг гарган Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
- 5.4. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвлөлийн дүгнэлтийг баталгаажуулан ажлын 10 хоногт багтаан Эрүүл мэнд, спортын яамны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвд хүргүүлнэ.

Зургаа. Насанд хүрэгчдийн Үндэсний шигшээ багийн тамирчныг чөлөөлөх:

- 6.1. Дараахь тохиолдолд Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнээс тамирчныг чөлөөлөх үндэслэл болно.
- 6.1.1. тамирчны амжилт буурсан, төлөвлөсөн амжилтаа биелүүлээгүй, олимпын эрх авч чадаагүй,
 - 6.1.2. эрүүл мэндийн хувьд ажиллах боломжгүй болсон нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон,
 - 6.1.3. гадаад улс оронд тэмцээн, наадамд оролцох үедээ улс орны нэр хүндийг унагаасан аливаа үйлдэл гаргаж олон улсын спортын холбоо арга хэмжээ авсан, тэмцээнд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хассан,
 - 6.1.4. тамирчин өөрийн буруутай үйлдлээр тэмцээн, наадам, тойргын тоглолт, барилдаан, тулаан, гараанаас хоцорсон,
 - 6.1.5. гадаад, дотоодын бэлтгэл цугларалтад гарсан үед хүндэтгэх шалтгаангүйгээр байраа орхин явах,
 - 6.1.6. ажлын байранд, гадаад, дотоодод бэлтгэл цугларалт, тэмцээн наадамд оролцох үедээ согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн,
- 6.2. Энэ журмын 6.1 дэх зүйлд заасан шийдвэрийг гарсан даруйд Эрүүл мэнд, спортын яам, Биеийн тамир, спортын хөгжлийн төв, Спортын холбооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 30 өдрийн
254 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛАХ ОРОН ТООНЫ
БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Эрүүл мэнд, спортын дэд сайд
Орлогч дарга:	Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/ Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Гишүүд:	ЭМСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн захирал
	ЭМСЯ-ны Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
	ЭМСЯ-ны Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
	ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн
	ЭМСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Үндэсний шигшээ багийн албаны дарга
	ЭМСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын хэлтсийн дарга
	ЭМСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Спортын анагаах ухааны албаны дарга
	Монголын үндэсний олимпын хорооны дэд ерөнхийлөгч
	Монголын паралимпийн хорооны дэд ерөнхийлөгч
Нарийн бичиг:	ЭМСЯ-ны харьяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Үндэсний шигшээ багийн албаны ахлах мэргэжилтэн